

явуулбал экологийнхоо аюулгүй байдлыг ч олон улсын экологийн аюулгүй байдлын салшгүй хэсэг болгох боломж байна.

**АЗИ-НОМХОН ДАЛАЙН ХАМТЫН  
НИЙГЭМЛЭГИЙН ДҮР ТӨЛӨВ, ТҮҮНД  
МОНГОЛЫН ЭЗЛЭХ БАЙР СУУРИЙН АСУУДАЛД  
Ц. Батбаяр\***

АНУ-ын Ерөнхийлөгч Билл Клинтон нэг жилийн өмнө Японд айлчлах үеэр Васэда Их сургууль дээр 7 дугаар сарын 7-нд хэлсэн үгэндээ “Номхон далайн шинэ хамтын нийгэмлэгийн” үзэл санааг анх дэвшүүлсэн билээ. Энэ үзэл санаа нь цагийн аясыг дагасан хоосон чамирхал бус, харин хүйтэн дайны дараахь Ази-Номхон далайн бүс нутгийн шинээр бүрэлдэн буй бодит байдлыг илэрхийлсэн санаачилга гэж хэлж болно.

Хүйтэн дайн шувтарснаар тус бүс нутгийн орнуудын хоорондын цэрэг-стратегийн болон газар нутгийн зөрчил маргаан үргэлжилсэн хэвээр байгаа боловч тэдний хоорондын худалдаа-эдийн засгийн харилцан хамаарал улам бүр нэмэгдэх төлөвтэй. Юуны өмнө, Азийн, ялангуяа Зүүн Азийн орнуудын түргэн хурдацтай эдийн засгийн хөгжил дэлхий нийтийн анхаарлыг татах боллоо. “Зүүн Азийн эдийн засгийн гайхамшиг” /The East Asian Economic Miracle/ төсөл ч үүнийг тод нотолж байна. Азийн орнууд нь 2 тэрбум хүн ам буюу, өөрөөр хэлбэл 2 тэрбум хэрэглэгчтэй асар том зах зээл болж хувирч байна. АНУ-ын Сангийн сайд Бентсений хэлснээр дундаж орлоготой америкчуудтай тэнцэх худалдан авах чадвартай өрх айлын тоо Азид зургаахан жилийн дараа 75 саяас давах ажээ.

Эх газрын Хятад, Тайвань, Гонконгийг хамарсан нэг ёсны “Их Хятадын эдийн засгийн бүс” бүрэлдэж байна. Түүн дотор сүүлийн арваад жилд тэрбум гаруй хүн амтай Хятадын эдийн засгийн Хөгжлийн хурдац жилд 10%-иас давж байна. Өнөөдөр дэлхий нийтийн дотоодын нийт бүтээгдэхүүний /Gross Domestic Product/-ын 23 орчим хувийг АНУ, 16%-ийг Япон эзэлж байгаа боловч ирэх 21 дүгээр зууны эхний хагаст Хятадын эдийн засаг үнэмлэхүй хэмжээгээр дэлхийн хамгийн том нь болох нь бараг эргэлзээгүй зүйл боллоо.

Нөгөө талаас, Ази-Номхон далайн бүс нутагт ардчиллын салхи үлээх төдий бус шуурга шуурч эхэллээ. Улс төрийн диктатур, тэр ч байтугай цэргийн дэглэм ноёрхсон оронд эдийн засгийн өсөлт

\* Ц. Батбаяр - Дэд доктор, ДДОУСХ-гийн захирал

үсрэнгүй байж болохыг Азийн зарим орны жишээ бэлхнээр харуулсан. Гэвч боловсролтой, чинээлэг хүн амын давхарга хичнээн нэмэгдэхийн сацуу улс төрийн ардчилал чөлөөт сонгуулийг төчнөөн шаарддаг нь өнөөдөр тод томруун ойлгогдлоо. Ардчилсан орнууд нь хоорондоо түншилж нөхөрлөж чаддаг, бие биентэйгээ дайн байлдаан хийдэггүй, алан хяддаггүй, дүрвэгсдийг төрүүлдэггүй нь нэгэнт тодорхой. Энэ ч утгаараа ардчилсан орнуудын хүрээ өргөжин тэлэхийг дагалдан бүс нутгийн тогтвортой байдал, хөгжил цэцэглэлтийн баталгаа улам бүр гүнзгийрнэ гэхэд хилсдэхгүй.

Дэлхий нийтийг хамарсан мэдээллийн өргөн солилцоо ч Ази тивийг тойрч гарсангүй. Факс машин, электрон шуудан, сателлит телевиз нь бидний амьдралыг хэдхэн жилийн өмнөхтэй харьцуулахад танигдашгүй болгон хувиргаж байна. Тяньаньмэнийн талбайд оюутнуудыг хэрхэн танкаар дайрч байгааг, Москвад цагаан ордныг хэрхэн их буугаар буудаж байгааг дэлхий даяар сая сая хүн тэр өдөрт нь харах бололцоотой боллоо.

Бүс нутгийн байдал төлөвийн талаарх Их гүрнүүдийн байр суурь. Тус бүс нутгийн одоогийн байдал, ойрын ирээдүйн дүр төлөвийн талаар юуны өмнө Америк, Орос, Япон, Хятад зэрэг их гүрнүүдийн байр суурийг товч боловч дурьдах нь зүйтэй. ЗХУ задран унаснаар Зөвлөлтийн цэргийн аюул үндсэндээ Азийн олон орны хувьд бодит зүйл биш боллоо. Ийм нөхцөлд АНУ-аас Япон, Өмнөд Солонгос зэрэг оронтой байгуулсан хоёр талын гэрээ хэвээр байх эсэх, байх аваас хэнээс юуг хамгаалахад чиглэх вэ гэдэг нь бүс нутгийн аюулгүй байдлын гол гогцоо асуудал болж хувираад байна. Азийн аюулгүй байдалд АНУ-ын шинээр гүйцэтгэх үүрэг Солонгосын хойгоос бусад нутагт төдийлөн тодорхой бус байна. Гэхдээ АНУ тус бүс нутгаас цэргээ яаран татах аваас цэргийн хүчний хоосон орон зай үүснэ гэдгээс азийнхан хамгийн их эмээж байна. Энэ нь хэд хэдэн шалтгаантай юм. Нэгд: Америк-Японы аюулгүйн гэрээг хэвээр хадгалах нь Японыг эдийн засгийн асар их чадавхиа цэргийн болгон хөрвүүлэх, өөрөөр хэлбэл цэргийн их гүрэн болгохгүй байх шилдэг арга гэж азийнхан үзэж байна. Хоёрт: зөвхөн Япон төдийгүй Хятадын эдийн засгийн боломж нэмэгдэхийг дагалдан түүний цэргийн “булчин” чангарахаас Азийн, ялангуяа АСЕАН-ы орнууд эмээх боллоо. Өмнөд Хятадын тэнгист байдаг Спратли арлыг эзэмших эрхээ хүчээр бататгах гэсэн БНХАУ-ын сүүлийн үеийн зарим алхмууд Малайз, Филиппин зэрэг нэлээд орны түгшүүрийг төрүүлж байна. Гуравт: Өмнөд Ази дахь Энэтхэг-Пакистаны өрсөлдөөнийг намжааж чадах бодит хүчин зүйл бол бүс нутаг дахь Америкийн тэнцвэржүүлэх үүрэг гэж үзэх нь түгээмэл боллоо. Эд болон бусад хүчин зүйлээс үүдэн Ази-Номхон далай дахь америкийн цэргийн гүйцэтгэх үндсэн үүрэг аажмаар өөрчлөгдөж байна гэж хэлж болно. Хүйтэн дайны үед энэ хүч Азийн орнуудын хувьд гаднын аюул заналын эсрэг бодитой баталгаа болж байсан бол эдүгээ Солонгосын хойгийг эс тооцвол

бусад салбар бүс нутагт үүсэж болзошгүй тогтворгүй байдлаас сэргийлэх тийм үүрэг гүйцэтгэх төлөвтэй.

Америкаас Азитай хийх худалдаа бүр 1970-аад оны сүүлчээр Европтой хийдэг худалдаанаас давсан бөгөөд өнөөдөр Америкийн нийт гадаад худалдааны 36%-ийг эзэлж байна. Ази дахь Америкийн хөрөнгө оруулалт гэхэд л 1991 оны байдлаар 63 тэрбум долларт хүрчээ. Америкийн цэрэг Азийн зарим орнуудад байгаа явдал тэдгээр орныг АНУ-тай худалдаа-эдийн засгийн харилцаагаа өргөтгөх байнгын баталгаа болж байна гэж америкчууд үзэж байна.

Нөгөөтэйгүүр тус бүс нутагт АНУ-ын стратегийн шинэ үүрэг гүйцэтгэх хүсэл зориг, боломж бололцоо байгаа эсэхэд эргэлзэж байгаагаа азийнхан илэрхийлэх боллоо. Бүс нутгийн голлох орнууд Япон, Хятадтай АНУ-ын хоёр талын харилцаа төдий л хэвийн бус, зөрчилтэй асуудлууд хуримтлагдах боллоо. Хятад зэрэг Азийн орнуудад хүний эрхийн талаархи өөрийн стандартыг тулган хүлээлгэх гэлээ гэсэн шүүмжлэл Азийн зарим орны нийслэлд яригдах боллоо. Азийн орнуудтай хийж байгаа худалдааны алдагдал байнгын маргааны эх үүсвэр хэвээр байна. Хамгийн гол нь Америкийн бүс нутаг дахь идэвхтэй, шаргуу оролцоог АНУ-ын Конгресс, олон нийтийн зүгээс өмнөхтэй адил дэмжихээ, больж, харин ч бүр багасгахыг шаардах болжээ.

Оросын Холбооны Улс нь өмнөх ЗХУ-ыг бодвол газар зүйн хувьд Ази-Номхон далайн орон гэж хэлэх үндэслэл ихтэй болжээ. Орос нь Сибирь, Алс Дорнодын байгалийн баялагаас улам бүр хамаарах болж, Хар далай, Балтийн усан боомтуудаа алдсанаас Номхон далайн боомтуудын ач холбогдол нэмэгджээ.

Цэргийн хүч чадлын хувьд “Их гүрэн” хэмээн тооцогдох Орос нь тус бүс нутгийн эдийн засагт оролцох оролцоогоо өргөтгөх зайлшгүй шаардлагатай тулгарч байна. Сибирь болон Алс Дорнодын районуудын хамтарсан хүч чармайлтаар 1992 оны 4 дүгээр сард боловсруулсан “Интергратор-XXI” программд их найдлага тавьж байна. Гэвч дэд бүтэц хөгжөөгүй, холбогдох хууль тогтоомж боловсронгуй бус, түүнчлэн Япон зэрэг томоохон оронтой газар нутгийн маргаантай асуудал байгаа, хамгийн гол нь Москва болон орон нутгийн төвүүд хоорондын эрх үүргийн ялгаа зааг тодорхой бус, эмх замбараагүй хэвээр байгаа нь байдлыг сайжруулахад ихээхэн сөрөг нөлөө үзүүлж байна.

Владивосток, Красноярскийн санаачлагаас хойш Оросын удирдлага бүс нутгийн талаар улс төрийн санал санаачилга гаргасангүй, гаргах цаг нь ч одоо биш гэдгийг ухаарсан бололтой. Гэвч НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн байнгын гишүүн, цөмийн зэвсэгтэй орны хувьд Орос нь бүс нутгийн аюулгүй байдлын олон талын механизмыг бий

болгоход зохих үүрэгтэй нь ойлгомжтой. 1992 оноос эхлэн ОХУ-ын ГЯЯ-ны сайд Хятадын нэгэн адил АСЕАН-ы орнуудын ГЯЯ-ны сайд нарын жил бүрийн хуралдааны дараа болдог Зөвлөлдөөнд оролцох болсон нь түүний оролцоог бодитой болгож буй нэгэн үзүүлэлт мөн.

Хэрвээ Орос улс “цэргийн Их гүрэн” бол Япон “эдийн засгийн Их гүрэн” болох нь тодорхой. Хүйтэн дайны дараа дэлхийд, тэр тусмаа Ази-Номхон далайд Японы үүрэг роль ямар байх вэ? Дэлхийн II дайнаас хойш бараг хагас зуун жил өнгөрч байгаа боловч энэ дайнд ялагдсан Япон өнөөг хүртэл Оростой найрамдлын гэрээ байгуулаагүй, Хятад болон Өмнөд Солонгос, Зүүн өмнөд Азийн орнуудын өмнө “нүглээ наминчилж” дуусаагүй л байна. Иймд ч саявтараас Азид шинээр байр сууриа тодорхойлох асуудлыг Японд өргөн хэлэлцэх боллоо. Японы улс төр, бизнесийн зарим томоохон зүтгэлтнүүд Японыг дахин Азид нь буцааж авчрах буюу “Нео -Эйншанизм” гэсэн үзэл санааг дэвшүүлэх боллоо.

Японы Ази-Номхон далайн стратеги нь тулгын гурван чулуун дээр тогтоно гэж үзэж байна. Нэгд: бүс нутгийн эдийн засгийн өсөлт Хөгжлийг дэмжиж, нээлттэй худалдаа, хөрөнгө оруулалтыг бүх талаар хөхүүлэх, хоёрт: бүс нутгийн энх тайвныг сахиулах механизмыг хүчтэй болгох, АНУ-тай байгуулсан аюулгүй байдлын гэрээг хадгалан бататгах, гуравт хуучин социалист орнууд, ялангуяа ОХУ, Хятад болон Вьетнамыг, бүс нутгийн хамтын нийгэмлэгийн хариуцлагатай гишүүн болгон нэгтгэж авах талаар ажиллах багтаж байна.

Япон нь эдийн засгийн аварга, улс төрийн давжаа биетэй” гэсэн нэр хочноос салахын тулд бусад их гүрэнтэй нэгэн адил “хэвийн л орон болох”, өөрөөр хэлбэл Үндсэн хуулиа шинэ байдалд зохицуулан засварлаж, НҮБ-ын Аюулгүй Зөвлөлийн байнгын гишүүн болж, дэлхий дахин болон бүс нутагт мөргөлдөөнийг зохицуулж, энх тайвныг сахиулахад зөвхөн мөнгө төгрөг хандивлах бус, харин хүн хүчний идэвхтэй оролцоо хийх хэрэгтэй гэсэн үзэл санааг Японы удирдлагын зарим шинэ үеийнхэн, түүн дотор Озава Ичиро шаргуу дэвшүүлж тавьж байна.

1989 оны Тяньаньмэнийн хэрэг явдлаас хойш хэдхэн жил өнгөрөхөд БНХАУ дипломат ганцаардлаас гарсан төдийгүй Ази-Номхон далайд байр сууриа бэхжүүлж чадлаа. Эхний фронт буюу Ази дахь хөрш зэргэлдээ орнуудтай харилцаагаа бүгдийг шахам хэвийн болгосны дотор Индонез, Сингапур болон Өмнөд Солонгостой дипломат харилцаа тогтоов. Тайвань, Гонконг болон Азийн бусад оронд суудаг нийт 27 сая орчим хуацяо нарын тусламжтайгаар олон зуун сая долларын гадаад хөрөнгө оруулалт оруулж, экспортын баазаа ихээхэн өргөтгөлөө. Хоёр дахь фронт буюу АНУ болон Европын орнуудтай харилцаагаа сэргээхдээ Бээжин өөрийн тэрбум гаруй хэрэглэгчтэй асар том зах зээлийн хүчин зүйлээ чадамгай овжин

ашиглаж чадсан байна. Ажилгүйдэлд нэрвэгдээд байгаа Европын орнууд Хятадын урхинд амархан оров. Бээжинг хүний эрхийг сахихгүй байна гэж ихэд шүүмжилдэг АНУ хүртэл жил бүр хүний эрхтэй холбон сунгадаг байсан “нэн тааламжтай орны статусаа” энэ жил онцын хэл амгүй сунгаж орхилоо. Үүнийг Бээжингийн нэг ёсны “улс төрийн ялалт” гэж ойлгохоос өөр аргагүй.

Хэдий тийм ч Бээжингийн хувьд 1990-ээд он хэд хэдэн хүнд сорилт авчрах нь дамжиггүй. Үүнд юуны өмнө Дэн Сяопинийн дараа Хятад ямар байхав, удирдлага солигдох явц тайван намуухан явагдах эсэх тодорхойгүй байна. Хамгийн гол нь өнөөг хүртэл “социалист таваарын аж ахуй” нэрээр явагдаж ирсэн зах зээлийн эдийн засаг нь коммунист үзэл сурталтай нэг намын системтэйгээ хэр удаан зохицон орших вэ, улс төрийн өөрчлөлт яаж явагдах вэ гэдэгт асуудлын гол гогцоо оршиж байна. Иймээс ч Хятадын удирдлага эдийн засгийн өсөлтийн гол зорилгоо болгон үүнийг хангах үндсэн нөхцөлд “улс төрийн тогтвортой байдал” гэсэн номлолоо шаргуу баримталж байна.

БНХАУ өнгөрсөн 5 жилд Тяньаньмэнийн хэрэг явдал, ЗХУ задран бутарч коммунист үзэл суртал дампуурсан хоёр их дотоод, гадаад шокийг амжилттай даван туулсан боловч дээр өгүүлсэн хэд хэдэн сорилтыг хэрхэн даван туулах нь төдий л тодорхой бус байна.

#### Монгол Улсын байр сүүрийн асуудалд юу өөрчлөгдсөн бэ?

Хэдхэн жилийн өмнө Монгол Улж Зөвлөлт-Хятадын харилцааны “барьцааны улс” мэт, газар зүйн хувьд Азийн орон мөртлөө улс төр, Эдийн засаг зэрэг бараг бүх харилцаа нь ЭЗХТЗ-ийн хүрээнд ЗХУ, Зүүн Евроттой холбогдсон орон байлаа. Тэгвэл өнөөдөр Монгол Улс ХХ зууны түүхэнд анх удаа хоёр хөршийн харилцааны хүрээнээс ангижран гарч, дэлхийн хамтын нийгэмлэгийн бүх орнуудтай чөлөөтэй харилцах, Азийн орныхоо статусыг эргэн сэргээх бололцоотой болоод байна.

80-аад оны сүүлчээс хойшхи ахархан богино хугацаанд Монгол Улсын дотоодод өрнөсөн ардчилал, зах зээлд шилжих процессын дүнд дэлхийн нөлөө бүхий томоохон орнууд АНУ, Япон, Өмнөд Солонгос, БНХАУ болон Ази-Номхон далайн бусад орнуудтай хэвийн харилцаатай боллоо. Монгол Улс ОУВС, Дэлхийн банк, Азийн, хөгжлийн банкинд гишүүнээр элсэж, Монгол Улсын шилжилтийн бэрхшээлтэй үеийг даван туулахад туслах донор орны хамтлаг бий болжээ.

90-ээд онд манай гадаад харилцаанд буй болсон нэг шинэ хүчин зүйл бол АНУ, Япон зэрэг Ази-Номхон далайд төдийгүй дэлхийн бодлогод шийдвэрлэх нөлөөтэй зонхилох орнууд тодорхой үүрэг гүйцэтгэх болсон явдал мөн. Үүний үндсэн шалтгаан нь Монголд

гарсан ардчилсан өөрчлөлт, хүний эрх, эрх чөлөө зэрэг үнэт зүйлийг Үндсэн хуулиндаа тунхагласан явдал мөн. Энэ ч үүднээс тэд Монгол орныг ленинист дэглэмээс ардчилсан тогтолцоонд шилжихэд бүх талын дэмжлэг үзүүлэх, хоёр хөршид нь амжилттай жишээ болгон харуулах зорилго тавьсан бололтой. Японы хувьд адилхан Азийн орон, түүхэн газар зүйн үүднээс Монголыг сонирхож ирсэн зэрэг утгаараа Монголыг илүү чухалчлах учир шалтгаан бас бий.

Ийнхүү Монгол Улсын гадаад харилцаанд АНУ, Японы шинэ хүчин зүйл бий болсныг дагалдаад бас нэг шинэ нөхцөл байдал бүрэлдсэнийг анхаарахгүй байж болохгүй. Хэрвээ өмнө нь Монгол Улсын гадаад орчин Зөвлөлт-Хятадын харилцаанаас бүрэн шахуу хамаардаг байсан бол өнөөдөр улам бүр эдгээр хөрш хоёр орноос Америк, Япон тус бүртэй харилцах хоёр талын харилцаанаас мөн хамаардаг болох төлөвтэй. Ялангуяа цаашдаа АНУ, Японоос Хятад улстай харилцах 2 талын харилцаа ямар нэг хэлбэрээр нөлөө үзүүлэх бололтой. Энэ нь Хятад улсын нийт бүс нутагт үзүүлэх нөлөө илт өсөж байгаа, түүнчлэн Монгол Улсын өмнөд, умард хөршийн хүчний балансад тэнцвэр алдагдаж, өмнөд хөршөөс Монгол Улсад үзүүлэх нөлөө, ашиг сонирхол нь улам нэмэгдэх байдалтай холбоотой.

Бас нэг асуудлыг тусгайлан хөндөхөд Ази-Номхон далайн салбар бүс нутаг дотроос Зүүн хойд Ази нь цаашдаа Монголын гадаад харилцаанд тэргүүн зэргийн нөлөөтэй гэж үзэж байна. Энд дэлхийн АНУ, Япон, Орос, Хятад гэсэн томоохон гүрнүүдийн ашиг сонирхол төвлөрч байдаг. Тэгээд ч Монгол Улс тэдний ашиг сонирхлын хүрээнд багтаж байгаа юм. Монгол Улс энэ салбар бүс нутагт багтах ёстой дэлхийн Ази судлаачид /Р. Скалатино нарын/, түүнчлэн Азийн улс орнуудын удирдлага дотор ч хүлээн зөвшөөрч байна. Иймд энд олж авсан байр сууриа Монгол Улс алдахгүй улам бататгахыг хичээх хэрэгтэй.

#### Цаашид юу хийх вэ?

Юуны өмнө далайд гарцгүй эх газрын Монгол орны хувьд дэлхийн зах зээлд татагдан орохдоо чухамхүү аль бүс нутгаар дамжин орох вэ? гэсэн асуудал тавигдаж байна. Үүнд Ази-Номхон далайн бүс нутаг, бүр тодруулбал Зүүн хойд Ази /үүнд Япон, БНХАУ, БНСУ, БНАСАУ, Монгол Улс, Оросын Алс Дорнод хамаарна/ хамгийн ирээдүйтэй болох нь тодорхой. Газар зүйн хувьд ойр дөт, далайд гарах гарц ч үүгээр дамжих төдийгүй Монгол Улсын цаашдын хөгжилд нэн шаардлагатай хөрөнгө капитал, техник, технологийн эх үүсвэр эдгээр орнуудад бий. Зүүн хойд Азийн орнуудыг аж үйлдвэрийн бэлэн бүтээгдэхүүн экспортлодог Япон, Өмнөд Солонгос болон Хятад, мөн түүхий эд ихэвчлэн гаргадаг Орос, Монгол болон БНАСАУ хэмээн 2

хуваан үзэж болох юм. Монголын түүхий эд голлосон экспортын бүтцийг өөрчлөхөд Япон, Өмнөд Солонгосын хамтын ажиллагаа нэн шаардлагатай. Экспортын нөөцийг тогтоох, анхан шатны боловсруулалт хийх замаар бүтээгдэхүүний өртгийг нэмэгдүүлэх, зам тээвэр, харилцаа холбооны дэд бүтэц төдийгүй, банк санхүүгийн дэд бүтцийг ч хөгжүүлэхэд Зүүн хойд Азийн бүс нутгийн орнуудын хамтын ажиллагаа тулгамдсан асуудал болж хувираад байна.

ОЛОН УЛСЫН  
ХАРИЛЦАА

**ӨМНӨД, УМАРДЫН ХАРИЛЦААНД  
ХӨГЖЛИЙН ОНОЛ БОДЛОГЫГ  
ХАРГАЛЗАХ ТАЛААР ЗАРИМ БОДОЛ**

**\* Б. Намсрай  
П. Доржсүрэн**

Монгол орон үйлдвэрлэлийн уналт үргэлжилж, үндэсний валютын солилцооны ханш нэн доогуур байгаагийн улмаас нэг хүн амд ногдох үндэсний нийт бүтээгдэхүүний үзүүлэлтээр хэмжсэн, хөгжлийн түвшингээр Өмнөдийн буурай хөгжилтэй орнууд, тэр ч байтугай зарим тооцоогоор бараг л нэн буурай хөгжилтэй орон (LLDC) гэдэг бүлэгт багтах болж байна. Энэ байдлаас хэрхэн гарах хөгжлийн стратеги, үзэл баримтлал боловсруулж, хэрэгжүүлэх нь өнөөдөр цаг үеийн нэн чухал зорилт болж байна.

Ингэхдээ Монгол Улс өөрийн хүлээх хариуцлагыг гүйцэд ухамсарлаж, үүнийгээ тод харуулах ёстой. Энэ хариуцлага нь юуны түрүүнд хөгжилд тус дөхөм үзүүлэх ерөнхий нөхцөлийг бүрдүүлэхэд оршино. Улс орны өөрийн чармайлтыг хандивлагч орнууд орлож, чадахгүй, тэгэх ч ёсгүй. Хөгжингүй Умартын орнуудын засгийн газар

1 Нэн буурай хөгжилтэй орон ("Least developed countries LCD) гэдэг ойлголт 1971 онд НҮБ нэн ядуу орныг ялгах зорилгоор нэвтрүүлсэн.

НҮБ-ын Ерөнхий Ассамблей НҮБ-ын хөгжлийн төлөвлөлтийн хороогоор шалгаж тогтоосны дараа LDC жагсаалтад тухайн орон орох эсэхийг шийддэг, Ингэхдээ энэ хороо гурван үзүүлэлт, хүн ам тутамд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүн, ДНБ-д аж үйлдвэрийн үйлдвэрлэлийн эзлэх хувийн жин, бичиг үсэг мэдэх хэр хэмжээ гуравт тулгуурладаг. Үүнийг хэрэглэх маяг бас үе үе өөрчлөгдөж байдаг, Сүүлчийнх нь 1989 оных бололтой. Одоо үед ДНБ хүн ам тутамд 473 US доллараас бага, ДНБ-дэх аж айлдвэрийн секторын хувь 10 хувиас доош, хүн амын бичиг үсэг үл мэдэгсдийн хувь 15 жил гаруй хугацаанд 20 хувиас доош байх ийм үзүүлэлт байна. Сүүлийн 2 үнэлгээ байгаа бол нэг хүнд ногдох ДНБ 567 US доллар байвал LDC орныг тодорхойлох шалгуурын талаар НҮБ-ын эрх мэдэл бүхий байгууллагад хэлэлцүүлэг маргаан хийгдсээр байна.

Монгол орны хувьд гэвэл оны үнээр ДНБ 1990 онд 10465,0 сая төг, 1991 онд 18909,6 сая төг, 1992 онд 47298,0 сая төг байна. Монголын эдийн засаг, нийгэм 1992 онд статистикийн эмхтгэл, 11 дэх тал) Үүнийг өнөөдрийн долларын дундаж ханшаар үнэлбэл ДНБ 1992 онд нэг хүнд 53,6 \$ орчим ногдож байна.